



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.08.03 № 45

Багшийн цалинг нэмэгдүүлэх
арга хэмжээний талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “АЛСЫН ХАРАА 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО-ыг баталсан байх ба энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА”-ны 2 дугаар зүйлийн 2.1.36 дахь хэсэгт “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, туслах багшийн ажлын ачааллыг ажлын байр, хөдөлмөрийн онцлогтой уялдуулж, тэдний үйл ажиллагааг үр дүнгээр нь үнэлж, цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгон бодит цалингийн хэмжээг улсын дунджаас дээш байлгана.”

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ийн 2 дугаар зүйлийн 2.2.3.3 дахь хэсэгт “Багшийн хөдөлмөрийн бүтээмжийг бодитоор үнэлж, багш, ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг төсөв, мөнгөний бодлоготой уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлж, улсын дундаж хэмжээнд хүргэж, нийгмийн баталгааг хангана.”

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.18-д “Багш ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг тэргүүн ээлжид сайжруулна.”

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “МОНГОЛ УЛСЫГ 2026-2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” 109 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн”-гийн 1 дүгээр зүйлийн 1.1.1.1, 1.1.2.2, 1.1.3.4 дэх хэсгүүдэд “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоож, бусад нийгмийн баталгааг сайжруулах” замаар “Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна.”, үндсэн хариуцагч нь Боловсролын яам, хамтран хариуцагч нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам байхаар, 3 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-д дээрх үр дүнг 1 дүгээр зүйлийн 1.1.1.1, 1.1.2.2, 1.1.3.4 дэх хэсэгт нарийвчилж, сургуулийн өмнөх, ерөнхий, мэргэжлийн боловсролын багшийн

үндсэн цалинг жил тутам Үндэсний статистикийн хорооноос гаргадаг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоох ба 2026 онд 2,800,000 төгрөгөөс доошгүй, 2027 онд 2026 оны түвшнээс дээгүүр, 2028 онд 2027 оны түвшнээс дээгүүр, 2029 онд 2028 оны түвшнээс дээгүүр, 2030 онд 2029 оны түвшнээс дээгүүр байхаар тус тус зааж өгчээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” 29 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-эд багшийн үндсэн цалинг 2026 оны улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоох үр дүн, шалгуур үзүүлэлтийг мөн зааж өгчээ.

Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан дээрх чиглэл, арга хэмжээг хэрэгжүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах;” чиг үүргээ биелүүлэхийг шаардаж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 151 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багш, ажилтны цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон байдаг. Энэ хэмжээгээр 2026 оныг дуустал багш, ажилтны цалинг хэвийн олгоход нийт хэдэн төгрөгний дутагдал үүсэж байгаа тухай болон түүнийг хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөж байгаа тухай мэдээллийг;

2.2026 онд багтаан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн үндсэн цалинг Үндэсний статистикийн хорооноос жил тутам шинэчлэн гаргадаг 2026 оны улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоох буюу 2,800,000 төгрөгт хүргэх талаар Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг;

3.Хэрвээ Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт дээрх хэмжээнд хүргэх төсвийн боломж байхгүй тохиолдолд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (Төсвийн тодотгол хийх) шаардлага үүсэх ба энэ талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг;

4.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэн баталсан Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон 2027 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулиудад цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн үндсэн цалинг 2026 оны

улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоох чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж буй талаарх мэдээллийг;

5.Багшийн цалинг Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасны дагуу шинээр тогтоож, өсгөн нэмэгдүүлэхийн зэрэгцээ багшийн үндсэн цалинг тогтоох, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшууллыг тооцох аргачлалыг түүнд нийцүүлэн зохистой шинэчлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Энэ талаар төлөвлөн хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг тус тус ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



C. Munkhtuya

Ц.МӨНХТУЯА

2026000131